



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/651

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 4.1, Засаг даргын зөвлөлийн 2023 оны 24 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод болсон Үндэсний уран хатгамалчдын анхдугаар чуулганд Хөвсгөл аймгаас төлөөлөгчөөр оролцсон Мөрөн сумын 8 дугаар багийн иргэн Ц.Бямбажавын ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэж замын зардалд 150.000 (Нэг зуун тавин мянган) төгрөгний дэмжлэг үзүүлсүгэй.

2. Замын зардалд шаардлагатай 150,000 (Нэг зуун тавин мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М. Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ